

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/026/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: [nyamsurenb@audit.gov.mn](mailto:nyamsurenb@audit.gov.mn)



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

### 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Ү.НАРАНТУНГАЛАГ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд удирдах 2, төрийн захиргааны албан тушаал 9, төрийн үйлчилгээний мэргэжлийн албан тушаал 2, гэрээт буюу туслах чиг үүргийн 9 албан тушаалтан, улс төрийн буюу багийн Засаг дарга 2, нийт 24 орон тоотой батлагдсанаас 24 орон тоотой ажилласан байна.

#### Аудитын гол асуудал

Тус байгууллагад тайлант онд 1 иргэн, 8 аж ахуйн нэгжээс 8,500.0 мянган төгрөгийн хандив тусламжийн орлого, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумын төвөөс төв зам руу 2.5 км хатуу хучилттай авто зам, ОНХС-ийн хөрөнгөөр зам дагуух гэрэлтүүлэг, камержуулалтын ажлуудад нийт 2,706,836.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлогод авсан байна.

#### Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 43 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 95,2 хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4110000098

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	141,381,140.10	119,365,086.59
33	АВЛАГА	11,476,913.05	4,140,520.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	725,013.03	350,000.00
335	Бусад авлага	10,751,900.02	3,790,520.00
3351	Байгууллагаас авах авлага	10,751,900.02	3,790,520.00
35	БАРАА МАТЕРИАЛ	129,904,227.05	115,224,566.59
354	Хангамжийн материал	119,214,227.05	101,458,566.59
35410	Бичиг хэргийн материал	803,300.00	2,393,040.00
35420	Аж ахуйн материал	43,040,984.30	41,084,753.84
35440	Түлш, шатах тослох материал	3,493,319.95	253,319.95
35450	Барилгын засварын материал	1,786,950.00	1,786,950.00
35460	Хүнсний материал	240,870.00	-
35470	Бусад хангамжийн материал	69,848,802.80	55,940,502.80
35500	Биологийн хөрөнгө	5,600,000.00	5,600,000.00
35600	Мал амьтад	5,090,000.00	8,166,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,119,145,309.73	4,890,458,871.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,119,145,309.73	4,890,458,871.87
392	Биет хөрөнгө	2,015,739,993.02	4,787,828,788.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,595,572,868.88	1,675,572,868.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	(419,351,424.23)	(278,957,752.26)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	236,585,745.00	571,808,406.13
39204	Хуримтлагдсан элэгдэл	(129,734,379.50)	(146,725,607.46)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	294,770,039.13	306,917,685.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(134,758,247.11)	(120,065,363.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,167,937.46	70,284,597.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,300,787.82)	(22,554,959.99)
39209	Зам, гүүрийн байгууламж	40,000,000.00	2,149,867,759.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,666,666.64)
39214	Бусад үндсэн хөрөнгө	556,185,603.00	690,842,754.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(79,397,361.79)	(106,494,932.70)
393	Биет бус хөрөнгө	103,405,316.71	102,630,083.37
39301	Програм хангамж	10,095,510.00	9,474,510.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,247,593.29)	(2,401,826.63)
39303	Бусад биет бус хөрөнгө	95,557,400.00	95,557,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,260,526,449.83</b>	<b>5,009,823,958.46</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,791,362.00	17,959,891.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,791,362.00	17,959,891.30
413	Өглөг	1,791,362.00	17,959,891.30
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	741,529.30
4136	Бусад өглөг	1,791,362.00	17,218,362.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,791,362.00	17,218,362.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,258,735,087.83	4,991,864,067.16
51	Засгийн газрын хувь оролцоо	2,258,735,087.83	4,991,864,067.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	190,427,442.83	190,427,442.83
51101	Өмч: - төрийн	190,427,442.83	190,427,442.83
512	Хуримтлагдсан үр дүн	1,642,983,965.15	4,387,206,455.66
51210	Өмнөх үеийн үр дүн	1,642,983,965.15	1,654,077,476.33
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	2,733,128,979.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	425,323,679.9	414,230,168.7
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,260,526,449.8</b>	<b>5,009,823,958.5</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,348,564,122.93</b>	<b>3,922,806,121.73</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	282,709,476.93	2,722,878,099.73
120	Нийтлэг татварын бус орлого	282,709,476.93	2,714,378,099.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,000.00	-
120009	Бусад орлого	1,374,762.00	-
122	Тусламжийн орлого	-	8,500,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	8,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,065,854,646.00	1,199,928,022.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	203,047,746.00	320,794,422.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	182,473,560.00	308,825,144.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,574,186.00	11,969,278.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	862,806,900.00	879,133,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	862,806,900.00	879,133,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>915,880,042.45</b>	<b>1,188,677,142.40</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	854,134,542.45	1,188,677,142.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	808,830,512.94	1,120,957,744.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	495,562,392.82	670,422,184.15
210101	Үндсэн цалин	309,986,965.44	389,195,352.10
210102	Нэмэгдэл	178,986,527.38	266,915,715.05
210104	Урамшуулал	6,588,900.00	14,311,117.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,712,427.98	76,477,809.54
210201	Тэтгэврийн даатгал	39,664,807.91	51,626,164.74
210202	Тэтгэмжийн даатгал	5,318,239.48	6,705,002.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,442,197.04	3,352,501.37
210204	Ажилгүйдлийн даатгал	2,218,980.72	2,956,589.77
210205	Эрүүл мэндийн даатгал	9,068,202.83	11,837,550.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,173,399.39	53,161,641.86
210301	Гэрэл, цахилгаан	5,897,159.39	5,885,401.86
210302	Түлш, халаалт	47,276,240.00	47,276,240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,614,467.66	27,653,341.64
210401	Бичиг хэрэг	3,523,036.00	4,973,260.00
210402	Тээвэр, шатахуун	24,180,980.00	14,491,682.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,910,451.66	3,188,399.64
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	1,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,500,000.00
2105	Нормативт зардал	366,000.00	146,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	366,000.00	146,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,003,000.00	3,966,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	90,000.00	-
210604	Урсгал засвар	24,913,000.00	3,966,900.00
2107	Томилолт, зочны зардал	7,632,000.00	4,270,000.00
210702	Дотоод албан томилолт	7,632,000.00	4,270,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,779,812.00	3,014,208.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,817,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,476,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	298,200.00	276,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	780,492.00	201,516.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,000,000.00	-
210807	Газрын төлбөр	999,120.00	928,482.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122,987,013.09	281,845,659.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,665,094.00	56,233,521.46
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,321,919.09	225,612,137.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,304,029.51	67,719,398.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,237,862.00	33,301,506.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,262,820.00	8,046,406.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,324,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,985,042.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	990,000.00	4,930,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,066,167.51	34,417,892.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,066,167.51	34,417,892.16
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	61,745,500.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	61,745,500.00	-
222001	Тоног төхөөрөмж	720,000.00	-
223001	Бусад хөрөнгө	61,025,500.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	432,684,080.48	2,734,128,979.33
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,235,000.00	1,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,235,000.00)	(1,000,000.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>429,449,080.48</b>	<b>2,733,128,979.33</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,069,863,708.00</b>	<b>1,209,278,022.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,374,762.00	8,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,374,762.00	-
122	Тусламжийн орлого	-	8,500,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	8,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,068,488,946.00	1,200,778,022.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	205,682,046.00	321,644,422.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	182,473,560.00	308,825,144.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,208,486.00	12,819,278.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	862,806,900.00	879,133,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	862,806,900.00	879,133,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>885,627,223.00</b>	<b>931,439,022.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	885,627,223.00	931,439,022.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	839,978,013.49	863,719,623.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	488,283,438.83	670,464,158.22
210101	Үндсэн цалин	301,247,567.11	382,426,417.41
210102	Нэмэгдэл	180,514,861.72	274,530,313.06
210104	Урамшуулал	6,521,010.00	13,507,427.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,741,381.99	75,353,013.12
210201	Тэтгэврийн даатгал	39,432,638.50	51,111,021.16
210202	Тэтгэмжийн даатгал	4,864,304.12	6,525,410.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,269,292.98	3,262,707.10
210204	Ажилгүйдлийн даатгал	2,233,130.88	2,888,538.76
210205	Эрүүл мэндийн даатгал	8,942,015.51	11,565,335.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,330,419.01	53,161,641.86
210301	Гэрэл, цахилгаан	5,897,159.39	5,885,401.86
210302	Түлш, халаалт	48,433,259.62	47,276,240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,637,631.66	22,936,281.64
210401	Бичиг хэрэг	3,399,200.00	3,296,900.00
210402	Тээвэр, шатахуун	20,950,980.00	11,381,682.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,987,451.66	3,188,399.64
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,300,000.00	1,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,569,300.00
2105	Нормативт зардал	999,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	999,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,170,200.00	4,010,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,676,900.00	-
210604	Урсгал засвар	17,493,300.00	4,010,900.00
2107	Томиллолт, зочны зардал	7,632,000.00	4,270,000.00
210702	Дотоод албан томиллолт	7,632,000.00	4,270,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,434,812.00	1,538,208.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,397,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	276,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	838,692.00	201,516.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,000,000.00	-

210807	Газрын төлбөр	999,120.00	928,482.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,749,130.00	31,985,421.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	164,749,130.00	31,985,421.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,649,209.51	67,719,398.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,583,042.00	33,301,506.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,608,000.00	8,046,406.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,324,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,985,042.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	990,000.00	4,930,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,066,167.51	34,417,892.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	184,236,485.00	277,839,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	184,236,485.00	277,839,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	184,236,485.00	277,839,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	184,236,485.00	277,839,000.00
221001	Их засвар	7,516,285.00	-
223001	Бусад хөрөнгө	79,984,700.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	96,735,500.00	277,839,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(184,236,485.00)	(277,839,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	144,833,442.83	426,608,340.96	428,961,028.83	1,000,402,812.62
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	144,833,442.83	426,608,340.96	428,961,028.83	1,000,402,812.62
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	66,727,319.51	66,727,319.51
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,427,442.83	425,323,679.85	1,642,983,965.15	2,258,735,087.83
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,427,442.83	425,323,679.85	1,642,983,965.15	2,258,735,087.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	11,093,511.18	11,093,511.18
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,427,442.83	425,323,679.85	1,654,077,476.33	2,269,828,599.01
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	2,733,128,979.33	2,733,128,979.33
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,427,442.83	414,230,168.67	4,387,206,455.66	4,991,864,067.16

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>895,062,441.00</b>	<b>834,168,600.00</b>	60,893,841.00	93.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	895,062,441.00	834,168,600.00	60,893,841.00	93.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	864,453,641.00	784,259,180.84	80,194,460.16	90.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	628,052,000.00	603,532,315.72	24,519,684.28	96.10
210101	Үндсэн цалин	374,564,900.00	382,426,417.41	(7,861,517.41)	102.10
210102	Нэмэгдэл	230,230,600.00	208,112,970.06	22,117,629.94	90.39
210104	Урамшуулал	23,256,500.00	12,992,928.25	10,263,571.75	55.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,495,341.00	67,791,394.62	10,703,946.38	86.36
210201	Тэтгэврийн даатгал	53,384,391.00	46,024,446.66	7,359,944.34	86.21
210202	Тэтгэмжийн даатгал	6,280,569.00	5,861,218.14	419,350.86	93.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,140,139.00	2,930,559.10	209,579.90	93.33
210204	Ажилгүйдлийн даатгал	3,137,952.00	2,592,755.76	545,196.24	82.63
210205	Эрүүл мэндийн даатгал	12,552,290.00	10,382,414.96	2,169,875.04	82.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,866,400.00	53,161,641.86	704,758.14	98.69
210301	Гэрэл, цахилгаан	6,590,100.00	5,885,401.86	704,698.14	89.31
210302	Түлш, халаалт	47,276,300.00	47,276,240.00	60.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,917,600.00	17,880,299.64	7,037,300.36	71.76
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	3,331,900.00	668,100.00	83.30
210402	Тээвэр, шатахуун	14,800,000.00	9,860,000.00	4,940,000.00	66.62
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,317,600.00	3,188,399.64	1,129,200.36	73.85
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	1,500,000.00	300,000.00	83.33
2105	Нормативт зардал	1,000,000.00	-	1,000,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	-	1,000,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	4,010,900.00	989,100.00	80.22
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,010,900.00	989,100.00	80.22
2107	Томилолт, зочны зардал	8,000,000.00	4,270,000.00	3,730,000.00	53.38
210702	Дотоод албан томилолт	8,000,000.00	4,270,000.00	3,730,000.00	53.38
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,421,800.00	1,538,208.00	1,883,592.00	44.95
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,476,000.00	-	1,476,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	400,900.00	276,210.00	124,690.00	68.90
210804	Тээврийн хэрэгслийн татвар	334,900.00	201,516.00	133,384.00	60.17
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	210,000.00	132,000.00	78,000.00	62.86
210807	Газрын төлбөр	1,000,000.00	928,482.00	71,518.00	92.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,700,500.00	32,074,421.00	29,626,079.00	51.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,700,500.00	32,074,421.00	29,626,079.00	51.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,608,800.00	28,370,806.00	2,237,994.00	92.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,608,800.00	28,370,806.00	2,237,994.00	92.69
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,784,300.00	8,046,406.00	737,894.00	91.60
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,324,500.00	20,324,400.00	100.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	-	1,500,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	94,000,000.00	45,000,000.00	49,000,000.00	47.87
2200	Дотоод эх үүсвэрээр	94,000,000.00	45,000,000.00	49,000,000.00	47.87
223001	Бусад хөрөнгө	94,000,000.00	45,000,000.00	49,000,000.00	47.87
<b>0</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>989,062,441.00</b>	<b>879,133,600.00</b>	109,928,841.00	88.89
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	982,158,100.00	879,133,600.00	103,024,500.00	89.51
132001	Орон нутгийн төсвөөс	982,158,100.00	879,133,600.00	103,024,500.00	89.51
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	5.00	5.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>97,394,422.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	97,394,422.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	79,584,443.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66,931,842.50
210102	Нэмэгдэл	66,417,343.00
210104	Урамшуулал	514,499.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,561,618.50
210201	Тэтгэврийн даатгал	5,086,574.50
210202	Тэтгэмжийн даатгал	664,192.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	332,148.00
210204	Ажилгүйдлийн даатгал	295,783.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Аудитаар нийт 374,299.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 12,430.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсөвт буцаан төвлөрүүлсэн 95,626.2 мянган төгрөгийг тохируулга хийж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Санхүүгийн үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 34,417.9 мянган төгрөгийг салгаж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4. Орон нутгийн төсвөөс санхүүжих орлого төсвийн хэлбэлзэлтэй 5,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “ангилал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5. Төсвийн гүйцэтгэлийн тайланд Сангийн сайдын А/3 дугаар тушаалын хавсралт маягтын дагуу тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6. Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсөв нь төсвийн хэлбэлзэлтэй 50,904.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

7. Төсвийн гүйцэтгэлийн тайланд гүйцэтгэл нь төсвийн хэлбэлзлийн гүйцэтгэлтэй 35.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

8. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд дахин үнэлгээний нэмэгдэл болох 271,512.7 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч бэлтгэснээр тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “ангилал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Залруулагдаагүй нийт 26,466.7 мянган төгрөгийн зөрчлөөс 8,253.5 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,301.8 мянган төгрөгөөр бага тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 26,466.7 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 8,253.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, 18,213.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүллээ.

### **5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### **5.2 Албан шаардлага**

1.Тус байгууллага тайлант онд сумын баяр наадмын зардалд 8,253.5 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Монгол Улсын Засгийн 271 дүгээр тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөр данстай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Тус байгууллага нь тайлант онд ажиллагсадтай холбогдсон өглөг 741.5 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 17,218.4 мянган төгрөг нийт 17,959.9 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

2. Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь Түлш, шатах тослох материалын 253.3 мянган төгрөгийн нөөц бүрдүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заалтыг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид нөөцлөх шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр нөөцлөхгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган  
төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага тайлант онд сумын баяр наадмын зардалд 8,253.5 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрлээ.	1	8,253.5			1	8,253.5		
Тус байгууллага нь тайлант онд ажиллагсадтай холбогдсон өглөг 741.5 мянган төгрөг, байгууллагад төлөх 17,218.4 мянган төгрөг нийт 17,959.9 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.	1	17,959.9					1	17,959.9
Тус байгууллага нь Түлш, шатах тослох материалын 253.3 мянган төгрөгийн нөөц бүрдүүлсэн байна.	1	253.3					1	253.3
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>26,466.7</b>			<b>1</b>	<b>8,253.5</b>	<b>2</b>	<b>18,213.2</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)